210502	Хоол, хүнс	555,836,100.00	362,578,595.00	301,235,800.00	296,421,614.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	38,116,300.00	37,566,100.00	25,834,500.00	48,913,900.00

**Арвайхээр сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>				
		428,407,800.00	407,974,150.00	260,333,500.00	332,956,778.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	59,701,500.00	57,232,700.00	88,399,100.00	87,669,100.00
210602	Тавилга	126,860,000.00	119,924,000.00	34,450,000.00	106,330,586.00
210604	Урсгал засвар	241,846,300.00	230,817,450.00	137,484,400.00	138,957,092.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>				
		17,693,900.00	4,811,100.00	9,098,200.00	5,141,700.00
210702	Дотоод албан томилолт	17,693,900.00	4,811,100.00	9,098,200.00	5,141,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>				
		1,342,563,700.00	1,332,680,015.00	35,975,100.00	169,797,949.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,327,393,100.00	1,318,177,605.00	32,396,600.00	165,047,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,906,400.00	8,342,400.00	554,400.00	554,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	191,000.00	95,910.00	118,500.00	217,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,000.00	310,900.00	320,000.00	551,382.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00	99,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,250,000.00	4,250,000.00	825,000.00	825,000.00
210807	Газрын төлбөр	1,404,200.00	1,404,200.00	1,661,600.00	2,481,117.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>				
		1,657,051,500.00	1,636,080,190.25	633,509,500.00	434,696,211.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,563,878,700.00	1,542,907,390.25	543,386,900.00	344,575,231.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	93,172,800.00	93,172,800.00	90,122,600.00	90,120,980.00
<b>212</b>	<b>ТАТААС</b>				
		201,600,600.00	179,588,300.00	153,304,000.00	151,934,000.00
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>				
		201,600,600.00	179,588,300.00	153,304,000.00	151,934,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	201,600,600.00	179,588,300.00	153,304,000.00	151,934,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>				
		420,458,800.00	317,057,927.00	468,555,700.00	541,228,352.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>				
		420,458,800.00	317,057,927.00	468,555,700.00	541,228,352.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	296,432,500.00	201,223,460.00	315,468,300.00	315,468,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	124,026,300.00	115,834,467.00	105,104,600.00	181,782,260.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>				
		<b>233,688,000.00</b>	<b>233,681,000.00</b>	<b>304,683,900.00</b>	<b>297,535,656.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>				
		233,688,000.00	233,681,000.00	304,683,900.00	297,535,656.00
223001	Бусад хөрөнгө	233,688,000.00	233,681,000.00	304,683,900.00	297,535,656.00

Арвайхээр сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	604,480,000.00	157,421,700.00	553,808,000.00	392,493,450.00
230001	Эргэж төлөгдөх зээл	604,480,000.00	157,421,700.00	553,808,000.00	392,493,450.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	20,808,538,200.00	19,621,230,069.81	20,550,585,500.00	21,078,741,976.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	15,395,123,700.00	14,862,255,518.88	15,242,077,100.00	15,241,502,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	15,395,123,700.00	14,862,255,518.88	15,242,077,100.00	15,241,502,700.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	4,136,977,200.00	4,462,388,041.93	4,218,890,000.00	4,560,482,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	3,859,914,200.00	4,185,325,041.93	3,878,692,900.00	4,220,285,500.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	277,063,000.00	277,063,000.00	340,197,100.00	340,197,100.00
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,276,437,300.00	296,586,509.00	1,089,618,400.00	608,516,068.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	746,200,000.00	230,452,992.00	668,084,000.00	535,485,068.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	68,337,000.00	66,133,517.00	72,380,000.00	73,031,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	461,900,300.00		349,154,400.00	-
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		23,225,192.35		14,654,970.10
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		14,654,970.10		45,531,555.69
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	29.00	24.00	29.00	24.00
610001	Төсвийн байгууллага	21.00	21.00	21.00	21.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	8.00	3.00	8.00	3.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	945.00	967.00	974.00	989.00
620001	Удирдах ажилтан	36.00	37.00	36.00	37.00
620002	Гүйцэтгэх ажилтан	679.00	682.00	679.00	682.00
620003	Үйлчлэх ажилтан	247.00	256.00	247.00	256.00
620004	Гэрээт ажилтан	12.00	14.00	12.00	14.00
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	11363.00	11136.00	11580.00	11471.00
630	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	8101.00	8239.00	8101.00	8239.00
630001	Төрийн өмчит ЕБС	8101.00	8239.00	8101.00	8239.00
631	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	3479.00	3232.00	3479.00	3232.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	3479.00	3232.00	3479.00	3232.00

Арвайхээр сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	0.00	0.00	0.00	0.00
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	0.00	0.00	0.00	0.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	974.0	989.0	974.0	989.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	27.00	28.00	27.00	28.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	13.00	13.00	13.00	13.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	907.00	918.00	907.00	918.00
650010	Гэрээт ажилтан	11.00	14.00	11.00	14.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	16.00	16.00	16.00	16.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,793,877,720.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,776,752,720.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,649,716,403.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>838,530,140.22</b>
210101	Үндсэн цалин	704,334,815.22
210102	Нэмэгдэл	73,809,825.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,585,500.00
210104	Урамшуулал	1,800,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>111,043,968.30</b>
210201	Тэтгэврийн даатгал	85,946,622.93
210202	Тэтгэмжийн даатгал	6,143,707.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,866,099.48
210204	Ажилгүйдлийн даатгал	1,189,776.24
210205	Эрүүл мэндийн даатгал	11,897,762.08
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>79,781,944.99</b>
210301	Гэрэл, цахилгаан	71,167,354.99
210302	Түлш, халаалт	7,841,250.00
210303	Цэвэр, бохир ус	773,340.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>182,344,344.90</b>
210401	Бичиг хэрэг	8,779,265.00
210402	Тээвэр, шатахуун	118,564,830.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,103,165.90
210404	Ном, хэвлэл	393,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,847,310.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,656,274.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>35,351,793.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,101,493.00
210502	Хоол, хүнс	5,313,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,937,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>156,387,690.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,022,440.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	24,612,500.00
210604	Урсгал засвар	113,752,750.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,391,376.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,391,376.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>49,816,887.54</b>

**Арвайхээр сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,179,045.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,628,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,533,645.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,682,438.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	528,000.00
210807	Газрын төлбөр	743,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	522,159.54
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>190,068,258.05</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	157,477,932.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,590,326.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>127,036,317.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>109,339,639.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,417,639.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	99,922,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>17,696,678.00</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	66
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	17,696,612.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>17,125,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>17,125,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,125,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,793,877,720.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,793,877,720.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	16,181,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	230,159,044.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,407,864,331.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	139,672,845.00

### **3.Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Арвайхээр сумын Төрийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022.03.16-нөөс 2022.03.25-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.03.24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ц.Мөнхзаяа хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.03.21-ны өдрийн 1/41 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Сумын төрийн сангийн нэгтгэсэн тайланд 21 төсөвт байгууллага / ЕБС 5, Цэцэрлэг 14, ИТХ, ЗДТГ /, өрхийн эмнэлэг 3, Арвайхээр тохижилт үйлчилгээ ААТҮГ, Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ, Арвайхээр нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨАТҮГ, 3 сан, ерөнхий орлогын данс, ахмадын сан, хувийн цэцэрлэг нийт 33 тайлан нэгтгэгджээ.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. "Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно." гэж заасан.

Мөн хуулийн 36.1. "Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

36.2. Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3. Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно." гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Арвайхээр сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арвайхээр сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 42 тэрбум 011 сая төгрөгөөс 1 хувиар буюу 420.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 315.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 138.9 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	2020 он	2021 он	Зөрүү	Эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	593.4	702.7	109.4	86
Арилжааны банк дахь харилцах	87.2	116.7	29.5	14
<b>Дүн</b>	<b>680.5</b>	<b>819.4</b>	<b>138.9</b>	<b>100</b>

### Мөнгөн хөрөнгө



#### 3.5.2 Авлага

Үзүүлэлт	2020 он	2021 он	Зөрүү	Эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	10.9	8.8	-2.2	1
Зээлийн хүүгийн авлага	23.1	24.5	1.4	2
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.8	0.0	-0.8	0
Байгууллагаас авах авлага	159.4	303.5	144.1	23
Хувь хүмүүсээс авах авлага	1035.0	1006.1	-28.9	75
<b>Дүн</b>	<b>1229.3</b>	<b>1342.9</b>	<b>113.6</b>	<b>100</b>

## Авлага

■ 2020 он ■ 2021 он

	2020 он	2021 он
Ажиллагчидтай холбогдсон авлага	10.9	8.8
Зээлийн хүүгийн авлага	23.1	24.5
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.8	0
Байгууллагаас авах авлага	159.4	303.5
Хувь хүмүүсээс авах авлага	1,035	1,006.1

Тайлант оны нийт авлагын 75 хувийг хувь хүмүүсээс авах авлага эзэлж байна. Энэ нь эрсдэлээс хамгаалах сан, сум хөгжүүлэх сангийн хувь хүмүүсээс авах авлага байна.


### 3.5.3 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 280.6 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	2020 он	2021 он
Тусгай зориулалттай материал	200.6	237.6
Эм боох материал	28.2	24.4
Бэлэн бүтээгдэхүүн	2.6	2.2
Бичиг хэргийн материал	23.9	25.3
Аж ахуйн материал	297.6	328.2
Сэлбэг хэрэгсэл	16.1	57.0
Түлш, шатах тослох материал	4.3	10.9
Барилгын засварын материал	40.2	44.4
Хүнсний материал	77.8	81.9
Бусад хангамжийн материал	668.2	830.0
Тэжээлийн нөөц	1.9	0.0
<b>ДҮН</b>	<b>1361.3</b>	<b>1641.9</b>

## Бараа материал

■ 2020 он ■ 2021 он




Тайлант онд бараа материалын үлдэгдэл тусгай зориулалтын материал, эм боох материал, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, бусад хангамжийн материал, хүнсээр нэмэгдсэн байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 23 тэр бум 222.5 сая төгрөгөөр өссөн байна.

## Үндсэн хөрөнгө



Арвайхээр сумын Төрийн сангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн нэгтгэлээр 23 тэр бум 222.5 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 378.7 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 22 тэр бум 843.8 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусгажээ. Харин 391.5 сая төгрөгийн хөрөнгийг акталсан, 68 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 333.8 сая төгрөгийн дахин үнэлгээний хорогдол гарсан байна.

### 3.5.5 Өр төлбөр

Үзүүлэлт	2020 он	2021 он
Ажилчидтай холбогдсон өглөг	10.2	12.9
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1.4	0.0
Байгууллагад төлөх өглөг	7.0	33.2
Хувь хүмүүст төлөх өглөг	2.9	2.3
<b>ДҮН</b>	<b>21.5</b>	<b>48.4</b>

### Өглөг

	байгууллагад төлөх өглөг	Ажилчидтай холбоотой өглөг	хувь хүмүүст төлөх өглөг
Өв. Ар. Соёмбо цогцолбор сургууль	5.4	12.2	
Өв. Ар. 4-р сургууль	0.6		
Арвайхээр	18	0.1	
Өв. Ар. 11-р цэцэрлэг	0.7		
Өв. Ар. Арвайхээр хотын нийтийн тээвэр гэрэлтүүлэг ААТҮГ	8.4		
Өв. Ар. 6-р цэцэрлэг		0.1	
Өв. Ар. Өрхийн эмнэлэг3		0.6	
Өв. Ар. 4-р сургууль			0.01
Өв. Ар. 11-р цэцэрлэг			2.3

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

#### 3.6.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2020 оны тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 2.124.8 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр 2.681.4 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	270.00	183.90	86.10	68.1
Хөрөнгийн албан татвар буу	5.50	5.77	(0.27)	104.8
Улсын тэмдэгтийн хураамж	25.00	38.03	(13.03)	152.1
Хог хаягдлын хураамж	260.00	259.09	0.91	99.6
Хөрөнгө борлуулсны орлого	196.00	470.92	(274.92)	240.3
торгуулийн орлого бусад	130.00	2.75	127.25	2.1
хадгаламжийн хүүгийн орлого	680.79	808.74	(127.95)	118.8
хүү торгуул	450.00	634.94	(184.94)	141.1
ан агнуурын орлого	-	54.60	(54.60)	
Газрын төлбөр	100.00	120.88	(20.88)	120.9
малын албан татвар	-	93.94	(93.94)	
Нохойны татвар	3.50	3.50	0.00	100.0
Ус рашааны ашигласны төлбөр	4.00	4.32	(0.32)	108.0
<b>Нийт дүн</b>	<b>2,124.79</b>	<b>2,681.38</b>	<b>(556.59)</b>	<b>126.2</b>

### **3.6.2 Орон нутгийн төлөвлөлт, гүйцэтгэл**

2021 онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 2 тэрбум 20.550,6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас улсын төсвөөс 15242.1 сая төгрөг, 4218.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1089.6 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийт 21079.2 сая төгрөг бүрдүүлжээ. Үүнд: 15241.5 сая төгрөгийг улсын төсөв тусгай зориулалтын шилжүүлгээс, 4560,5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 668.2 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 609.0 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 19545.0 сая төгрөг, хөрөнгийн зардалд 297.5 сая төгрөг, эргэн төлөгдөх зээлд 392.5 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 541.2 сая төгрөгийг зарцуулжээ.

#### **Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар сумын хэмжээнд 1793.8 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд 1649.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 17.1 сая төгрөг, тэтгэмж урамшуулалд 109.3 сая төгрөг зарцуулжээ.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Арвайхээр сумын Төрийн сан нь 2021 онд 154 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 153 мэдээллийг ил тод мэдээлсэн, 1 мэдээллийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд зөрчил илрээгүй.

### 3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 10.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитаар тооцож бүртгэсэн үр өгөөж байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Арвайхээр сумын Төрийн сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд зөрчил илрээгүй.

### 4.1 Харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 29 байгууллагын 21 байгууллагад дүгнэлт гаргаж, 8 байгууллагыг түүвэрт хамруулсан. Эрсдэлээс хамгаалах сан, ахмадын сан, хувийн цэцэрлэг, сумын Ерөнхий орлогын дансыг аудитад хамруулаагүй.

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр 1290.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 50.0 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 3.4 сая төгрөгийн зөрчилд акт, 892.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 345.1 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг хүргүүлсэн. Арвайхээр сумын 5-р цэцэрлэг, 1-р цэцэрлэг, Иргэдийн төлөөлөгчдийн хурал 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан байна.

-ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг /Соёмбо цогцолбор, 5-р сургууль, 2-р цэцэрлэг, 4-р цэцэрлэг, 5-р цэцэрлэг, 8-р цэцэрлэг, 12-р цэцэрлэг, ИТХ, ЗДТГ, Тэмүүлэл эрдэм сургууль, 7-р цэцэрлэг, 6-р цэцэрлэг/ зөрчиж нормын хувцас, тавилга эд хогшил бэлтгэж, уралдаан тэмцээн зохион байгуулсан байна.

- Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой алдаа зөрчил илэрсэн. Үүнд:  
**Соёмбо цогцолбор**- Бараа үйлчилгээний бусад зардлаас 94.0 мянган төгрөгийн томилолтын зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага зардлаас ХАОАТатварт 110.0 сая төгрөгийн гүйлгээг төсвийн зардлын ангилал зөрчиж гаргасан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулж баталж мөрдөөгүй байна  
**4-р сургууль**- Боловсролын хөрөнгө оруулалтаар ирсэн 2890.8 мянган төгрөгийн хөгжмийг орлого авалгүй үлдээснийг аудитын явцад орлого авч тайланг залруулан гаргаж.  
**5-р сургууль**- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, аливаа төрлийн худалдан авалт, үйлчилгээний зардалд И-баримтыг үндэслэн зардлаар хүлээн зөвшөөрөх  
**1-р цэцэрлэг**-Ээлжийн амралт 13 албан хаагчдад нийт 656.95 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна. Анхан шатны баримтын хөтлөлтөд тавих хяналт сул

/цагийн бүртгэл ээлжийн амралтын мэдээгдэл зөрүүтэй, няравын тайланг нягтлан бодогч бүрэн баталгаажуулаагүй/ байна.

**2-р цэцэрлэг**-Үндсэн хөрөнгө бараа материалын тайлан хангалтгүй. Өмнөх оны хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг зөрүүтэй татсан.

**4-р цэцэрлэг**-Байгууллагын биет бус хөрөнгийн бүртгэлд байгаа 713.3 мянган төгрөгийн 2 санхүүгийн программ нь 2017 оноос хойш ашиглагдаагүй, байгууллагын нягтлан бодогчийн компьютерын санах ойд хадгалагдаагүй

**5-р цэцэрлэг**-Бичиг хэрэг, эмийн тооллого дутуу хийгдсэн, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан бэлтгээгүй, мөнгө хүсэх өргөдөл, бэлэн мөнгөний орлогын баримт, зарлагын баримт хөтлөөгүй, 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар хүнсний үлдэгдэлд тулгалт хийхэд үхрийн мах 194.65 кг мах, хонины мах 11.75 кг, цагаан будаа 232.5 кг дутсан

**8-р цэцэрлэг**-2380.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, 150.0 мянган төгрөгийн халуун хэмжигчийг орлого авч, үлдэгдлээр тусгасан ч жилийн эцсийн тооллогын бүртгэлд тусгаагүй байна.

**11-р цэцэрлэг**-Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийн товчоо, бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл маягтуудаар бараа материалын орлого зарлагын хөдөлгөөний тайланг гаргаагүй байна.

**14-р цэцэрлэг**-Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас 1,520.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 1,200.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж зориулалт бусаар зарцуулсан, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй шинэ хөрөнгийг бараа материалд давхардуулан тоолсон, цагийн нэгдсэн бүртгэлийг цаг бүртгэл хөтлөх албан тушаалтан бүрэн хөтөлж баталгаажуулаагүй, анхан шатны баримтын хөтлөлтөд тавих хяналт сул байна.

**ИТХ**-Албан хаагчдад тэтгэмжийг хавтгайруулан олгосон. Бараа үйлчилгээний бусад зардлаас нэг удаагийн тэтгэмж олгосон.

**ЗДТГ**-Шатахууны зардлын тайланд анхан шатны баримтын бүрдэлгүй шууд зардалд бичсэн, санхүүгийн тайлангаарх авлагыг баталгаажуулаагүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж баталж мөрдөөгүй байна.

**Уян сэтгэл өрхийн эмнэлэг**-Тайлант онд ээлжийн амралтын цалингийн дүнд хоолны хөнгөлөлтийг оруулж тооцоноос 320,3 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна. Тайлант онд 4 хүнд 2950,0 мянган төгрөгийн урьдчилгаа олгоод 1750,0 мянган төгрөгийг суутгаж 1200,0 мянган төгрөгийг суутгаагүй, жилийн эцсийн санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна. Шатахууны зардалд 3802,4 мянган төгрөгийн зардал гаргасан боловч жолоочийн тооцооны хуудсыг хөтөлснөөс өөр баримтгүй, сар бүр шатахууны тайланг гаргаагүй, тооцоог бодоогүй. Тус байгууллагын эд хариуцагч нь бараа материалын орлого зарлагын падаан хөтөлдөггүй, эм болон бусад бараа материалын тайланг сар улирлаар гаргадаггүй, жилээр ганц удаа гаргасан боловч шаардах хуудсыг тухайн тайландаа хавсаргаагүй бөөнд нь хавсаргасан. Бараа материалын тайланд хавсаргасан баримтын тоо хэмжээ тавиагүй нягтлан бодогч хянаж гарын үсэг зураагүй. Тооллогын комисс нь тооллогын бүртгэлийг хөрөнгө, бараа материалын нэр төрлөөр хөтлөөгүй зөвхөн ажилчин албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлээр хийсэн. Нягтлан бодогч нь тооллогын дүнг гаргаж эд хариуцагчийн тооцоог бодоогүй, Тус ӨЭМТөө нь өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон дотоод хяналт шалгалтын журам боловсруулж мөрдөөгүй байна.

**Түшиг дөлгөөн өрхийн эмнэлэг**-Нэмэлт санхүүжилтийн орлогын тайлан гаргаагүй

**Нарны дөш өрхийн эмнэлэг**-Нэмэлт санхүүжилтийн орлогын тайлан гаргаагүй

**Арвайхээр Тохижилт үйлчилгээ ААТҮГ-Хөрөнгийн тооллого, жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягтын дагуу хөтөлсөн, Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс зардлаас нохой устгах зардал гаргасан, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авсан гэрээг зөрчиж уг ажлыг өөр байгууллагаар гүйцэтгүүлсэн**

**Арвайхээр нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨАТҮГ- Нийтийн тээврийн зорчигчийн тасалбараар орлогын тооцоог сар бүр хийсэн боловч тухай бүр кассад мөнгийг тушаадаггүй, тасалбарын үлдэгдлийг тоолж тооцоог боддоггүй, 2021 оны 12-р сарын 31-ны байдлаар санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулгын хэсэгт 2201.3 мянган төгрөгийн үлдэгдэл байгаагаас тооллого хийгдээгүй байна. 2020 оны энэ зөрчил дахин давтагдсан. Кондукторын орлогоос 2021-9-20-нд кабель утасны үнэнд 208.0 мянган төгрөг, 2021-9-22-нд жанам засварын үнэнд 60.0 мянган төгрөг нийт 268.0 мянган төгрөгийг зарлагын баримтгүйгээр мөнгө олгохыг хүссэн өргөдлөөр өгч кассын тайланд тусгаагүй.**

**10-р цэцэрлэг-Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас ХЧТА-ны тэтгэмжийн зардалд зориулалт бус зарцуулсан. Хүүхдийн хоолны зардлыг зориулалт бус зарцуулсан. Албан томилолтыг анхан шатны баримтын бүрдэл дутуу олгосон.**

**3-р цэцэрлэг-Үндсэн хөрөнгийн тавилга эд хогшил, машин тоног төхөөрөмжийн элэгдлийг 5,032.4 мянган төгрөгөөр илүү тооцсоныг залруулсан. Бараа материалын тайлан болон шаардах хуудсыг батлагдсан маягтын дагуу хөтөлж тайланг гаргаагүй байна.**

**13-р цэцэрлэг- Бараа материалын тайланг батлагдсан маягтаар сар бүр гаргаагүй байна. Хөрөнгийн тооллогын бүртгэл, тооцоо бодсон актыг байгууллагын нийт хөрөнгийн дүнгээр товчоолж бэлтгээгүй.**

**6-р цэцэрлэг- Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд цалин хөлсийг дутуу тайлагнасан. Хүүхдийн хоолны зардлыг нормативаас хэтрүүлэн зарцуулсан. Цэвэр бохир усны зардлаас зориулалт бус зарцуулсан. Дахин үнэлсэн үндсэн хөрөнгийг буруу бүртгэсэн. Шинээр худалдан авсан үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй. Нийгмийн даатгалын тайланд цалин хөлсийг дутуу тайлагнаснаас үүссэн өглөг тусгаагүй.**

• **Нийцлийн аудитаар илэрсэн зөрчил**

**Шилэн дансанд мэдээлэл дутуу байршуулсан, хугацаа хоцорсон зэрэг зөрчил илэрсэн байна.**

**Үүнд: 1-р сургууль, Соёмбо цогцолбор, 5-р сургууль, 1-р цэцэрлэг, 12-р цэцэрлэг, ИТХ, ЗДТГ, Түшиг дөлгөөн өрхийн эмнэлэг, Нарны дөш өрхийн эмнэлэг, 6-р цэцэрлэг, Арвайхээр нийтийн тээвэр гэрэлтүүлэг, 3-р цэцэрлэг/**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

(сая төгрөгөөр)

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Арвайхээр сумын Төрийн сан	0	0	0	00	0	0	0	0	0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР  Ц.МӨНХЗАЯА

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24 -НЫ ӨДӨР